

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хавсралт 1

**ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-н Компанийн засаглалын үнэлгээний асуулга**

**НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

**Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна.**

| № | Зүйл                                                                                                                                                                            | Хэрэгжилт          | Тайлбар                                                                                                                                                       |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 1.1 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна. | Биелүүлсэн         | Компанийн ТУЗ-ийн одоогийн мөрдөгдөн ажиллаж байгаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд эдгээр чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан тусгасан.                         |
| 2 | 1.2 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.          | Бүрэн хэрэгжүүлсэн | ТУЗ 2020 оны 10 сарын 23-ны өдөр ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны журмыг шинэчлэн баталсан бөгөөд уг журамд ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааны бодлогыг тусгасан. |

|   |                                                                                                                                                                                                                                                                       |                         |                                                                                                                                                                                                                                       |
|---|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 3 | 1.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна. | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд эдгээр мэдээллүүдийг тусгадаг боловч өөрийн цахим хуудсанд байршуулаагүй. Цаашид өөрийн цахим хуудсанд байршуулахаар ажиллаж байгаа.                                                         |
| 4 | 1.4 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.    | Бүрэн хэрэгжүүлсэн      | Компанийн дүрэм, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын дүрэм, журамд эдгээр асуудлуудыг тусгасан.                                                                                                                                       |
| 5 | 1.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтанд тогтмол хамруулна.                                                    | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход сургалт зохион байгуулдаг бөгөөд цаашид ТУЗ-ийн гишүүд ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ мэдээлэл гэх мэт ур чадвар олгох сургалтыг зохион байгуулах давтамжийг нэмэгдүүлэх шаардлагатай. |
| 6 | 1.6 Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.                                                                          | Бүрэн хэрэгжүүлсэн      | ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан.                                                                                                                                                                                              |

## ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагаан тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ.

|   |                                                                                                                                                                                                                                                                                                                                                               |                    |                                                                                                                                                                                            |
|---|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7 | 2.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.                                                                                                                                                                                                                                    | Бүрэн хэрэгжүүлсэн | Уг асуудлыг Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг бөгөөд өнөөгийн байдлаар ТУЗ 3 хараат бус гишүүнтэй.                                                              |
| 8 | 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.                                                      | Бүрэн хэрэгжүүлсэн | Аудитын хороо өөрийн дүрмээр зохицуулагддаг бөгөөд зөвхөн ТУЗ-ийн хараат бус гишүүн дарга болох боломжтой.                                                                                 |
| 9 | 2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно. | Бүрэн хэрэгжүүлсэн | ТУЗ-ийн цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журамаар зохицуулагддаг бөгөөд бодлогын баримт бичигтэй. Мөн зөвхөн ТУЗ-ийн хараат бус гишүүн дарга болох боломжтой. |

|    |                                                                                                                                                                                                                                                                                                   |                         |                                                                                                                              |
|----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 10 | 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.                                                           | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журамтай боловч ТУЗ-ийн ердийн гишүүн тус хорооны даргаар ажилладаг. |
| 11 | 2.5 Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна. | Бүрэн хэрэгжүүлсэн      | Эдгээр шаардлагуудыг бүгдийг ханган ажилладаг бөгөөд цаашид улам сайжруулах тал дээр анхаарах болно.                         |

### **ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ**

**Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана.**

|    |                                                                                                                                                     |                         |                                                                                   |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------------------------------------------------------------|
| 12 | 3.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.                         | Бүрэн хэрэгжүүлсэн      | Компанийн мэдээллийн үйл ажиллагааны журмаар зохицуулсан.                         |
| 13 | 3.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ. | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Компанийн засаглалын мэдээллийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан мэдээллэдэг. |

|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                         |                                                                                                                           |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 14 | 3.3 Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна. | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Компанийн санхүүгийн тайлан тэнцвэртэй, тодорхой, бодит бөгөөд үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг тусгадаг. |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------|

**ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО**

**Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана**

|    |                                                                                                                                                                                                                                                 |                         |                                                                                                                                                                 |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 15 | 4.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина. | Бүрэн хэрэгжүүлсэн      | Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамаар уг харилцааг зохицуулдан хэрэгжлтэд хяналт тавидаг.                                                           |
| 16 | 4.2 Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.                                                                                                   | Хугацаатай хэрэгжүүлэх  | ХЭХ-д хөндлөнгийн аудитор оролцож байгаагүй боловч цаашид тогтмол оролцуулж байх боломжтой.                                                                     |
| 17 | 4.3 Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.               | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Компани одоогийн байдлаар дотоод аудитын хэлтэс, ажилтангүй боловч зээлийн хороо, комплайнсын ажилтантай. Цаашид уг хэлтэс нэгжийг байгуулахаар ажиллаж байгаа. |

**ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

**Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон комплаенсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина**

|    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            |                         |                                                                                                                                                                                               |
|----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 18 | 5.1 Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.                                                                                                                                                                                                                                                                   | Бүрэн хэрэгжүүлсэн      | Компани ТУЗ дэргэдэх Эрсдэл аудитын хороотой бөгөөд даргаар хараат бус гишүүн ажилладаг.                                                                                                      |
| 19 | 5.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана. | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг. |
| 20 | 5.3 Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.                                                                                                                                                                                                                                            | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Эрсдэлийн хорооноос холбогдох шийдвэрүүд гардаг боловч нэг бүрчлэн олон нийтэд мэдээллэдэггүй. Цаашид тайлагналыг сайжруулна.                                                                 |
| 21 | 5.4 Компани нь комплаенсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплаенсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.                                                                                                                                                                                                                                                                      | Бүрэн хэрэгжүүлсэн      | Компани комплаенсын ажилтантай бөгөөд комплаенсын хяналтын хэрэгжилтийн үр дүнг ТУЗ-д тайлгандаг.                                                                                             |

**ЗУРГАА ДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ**

**Эрх бүхий албан тушаалтны цалин, зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.**

|    |                                                                                                                                                                                    |                         |                                                                                                                    |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 22 | 6.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.                                   | Бүрэн хэрэгжүүлсэн      | ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээ гэх мэтийг ХЭХ-аар хэлэлцэн шийдвэрлүүлдэг.                             |
| 23 | 6.2 Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана. | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Ажилтан бүрийг гүйцэтгэлээр үнэлдэг бөгөөд гэрээнд ерөнхий байдлаар тусгасан.                                      |
| 24 | 6.3 Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.                                     | Бүрэн хэрэгжүүлсэн      | Үндсэн цалинд өөрчлөлт орох, шагнал урамшуулал олгох тохиолдолд компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгадаг. |

**ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**

**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ**

|    |                                                                                                                                                                                                                                                                                                     |                    |                                                                                                                                                                                         |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 25 | 7.1 Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. | Бүрэн хэрэгжүүлсэн | Компанийн ёс зүйн дүрэм болон Комплайнсын хөтөлбөрт оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар Харилцааны зарчим, ёс зүйн хэм хэмжээ, ашиг сонирхлын зөрчлийн талаар тусгасан. |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

|                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                                                   |                         |                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 26                                                                                                                                                                 | 7.2 Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.                                             | Хэсэгчилэн хэрэгжүүлсэн | Жилийн үйл ажиллагааны тайланд хамтран ажилласан байгууллагын талаар тусгадаг бөгөөд хамтран ажиллах байгууллагыг сонгоходоо ТУЗ хурлаар хэлэлцдэг.                                                                                                                                                                 |
| 27                                                                                                                                                                 | 7.3 Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.                                                                                                   | Хугацаатай хэрэгжүүлэх  | Компанийн цахим хуудсыг сайжруулж, нэмэлт мэдээлэл оруулна.                                                                                                                                                                                                                                                         |
| 28                                                                                                                                                                 | 7.4 Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.                                                       | Бүрэн хэрэгжүүлсэн      | Уг асуудлыг тухайн ажилтантай хийх хөдөлмөрийн гэрээгэр зохицуулдаг мөн ажилчдийн нийгэм, эрүүл мэнд, ур чадварыг дээшлүүлэх үүднээс Сургалт болон эрүүл мэндийн үзлэгийн зардлын жил болгон үйл ажиллагааны зардалд тусгадах, ажилчдыг хөнгөлөлттэй орон сууцны зээлд хамруулах гэх мэт арга хэмжээг хэрэгжүүлдэг. |
| <b>НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ</b>                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                   |                         |                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| <b>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн хөндөх хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно</b> |                                                                                                                                                                                                                                   |                         |                                                                                                                                                                                                                                                                                                                     |
| 29                                                                                                                                                                 | 8.1 Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина. | Бүрэн хэрэгжүүлсэн      | Компанийн үнэт зүйл алсын харааг тодорхойлсон бөгөөд ёсзүйн дүрмийг ТУЗ хурлаар баталж, дагаж мөрддөг.                                                                                                                                                                                                              |

|                                                                                                                                                                      |                                                                                                                                                                                                                                     |                        |                                                                                              |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------|----------------------------------------------------------------------------------------------|
| 30                                                                                                                                                                   | 8.2 Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүтэл үлээгчийн" тогтолцоотой байна.                                                                  | Бүрэн хэрэгжүүлсэн     | Компанийн ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх журам болон авлигаас эсрэг журманд тусгаж өгсөн. |
| 31                                                                                                                                                                   | 8.3 Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.                                                         | Бүрэн хэрэгжүүлсэн     | Компанийн ёсзүйн дүрмээр тусгайлан зохицуулж өгсөн.                                          |
| <b>ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ</b>                                                                                                                     |                                                                                                                                                                                                                                     |                        |                                                                                              |
| <b>Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана.</b> |                                                                                                                                                                                                                                     |                        |                                                                                              |
| 32                                                                                                                                                                   | 9.1 Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ. | Бүрэн хэрэгжүүлсэн     | Өөрийн болон СЗХ, МХБ-ийн цахим хуудасаар дамжуулан тухай бүр хүргэдэг.                      |
| 33                                                                                                                                                                   | 9.2 Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.                                                                                           | Хугацаатай хэрэгжүүлэх | Цахим шуудангаар холбогдох мэдээллийг хүргэдэг. Цаашид цахим систем хөгжүүлэх                |
| 34                                                                                                                                                                   | 9.3 Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хурал оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.                                                       | Бүрэн хэрэгжүүлсэн     | КТХ болон Компанийн дүрэмд заасны дагуу ХЭ эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.           |
| 35                                                                                                                                                                   | 9.4 Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.                                                                             | Бүрэн хэрэгжүүлсэн     | КТХ болон Компанийн дүрэмд заасны дагуу ХЭ эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.           |

|    |                                                                                                                                                                                     |                    |                                                                                                                                                                                  |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 36 | 9.5 Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ. | Бүрэн хэрэгжүүлсэн | Компанийн ёс зүйн дүрэм, Авлигын эсрэг үйл ажиллагааны журам, Сонирхлын зөрчлийг тодорхойлох сэргийлэх мэдээлэх журам гэх мэтийн дагуу МХБ цахим хуудасаар дамжуулан мэдээллдэг. |
|----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|